



ХЭНТИЙ АЙМГИЙН
ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 08 өдөр

Дугаар 459

Дэлгэрхаан сум

Ногоон байгууламж бий болгоход
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 63 дугаар зарлиг, Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 19-ний 23 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлага "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын төвд ногоон зурвас байгуулахад хөрөнгө зарцуулсугай.

2. Ногоон зурвас байгуулахад шаардагдах 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийн зардлыг " Шилхэнцэгийн оюут чулуу " хязгаарлагдмал хувьцаат компаний дансанд шилжүүлсүгэй.

3. Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгдсөн ажлын хүрээнд, амьдрах чадвар сайтай хөрсөн тохирсон тарьц суулгацыг нийлүүлж, бүрэн хашаажуулах ажлыг "Шилхэнцэгийн оюут чулуу" хязгаарлагдмал хувьцаат компаний захирал (Д.Эрдэнчулуун)-д, суурин газарт ногоон байгууламж байгуулах төлөвлөгөөний зураглалтай уялдуулж ногоон байгууламжийг бий болгож ажиллахыг байгаль хамгаалагч (Х.Мөнхбат)-д, хяналт тавьж ажиллахыг байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (У.Ариунтуяа)-д үүрэг болгосугай.

4. Дээрх ажилд шаардагдах хөрөнгийг холбогдох иргэдийн дансанд шилжүүлэхийг нягтлан бодогч (О.Анхцэцэг)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Д.Батнасан) нарт даалгасугай.

ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

2329010118

